



УАГ
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

ЦАГ УУР ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗРЫН 2015 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Аудитын тайлан

**Нэмэлт мэдээлэл авахыг
хүсвэл дараах хаягаар
харилцана уу:**

УАГ-ын Санхүүгийн аудитын
газрын дарга С.Энхзаяа
Утас: 261663
Цахим хаяг:
enkhzayas@audit.gov.mn

Аудитын менежер:
Г.Гүнжидмаа
Утас: 261885
Цахим хаяг:
gunjidmaag@audit.gov.mn

Шинжээч : Н.Энхмэнд
Утас: 261740
enkhmendn@audit.gov.mn

Монгол Улсын Үндэсний
аудитын газар

Засгийн газрын IY байр
Улаанбаатар-46
Бага тойруу 6

Цахим хаяг: www.audit.mn

АГУУЛГА

ХУУДАС

- Хавсралт 1: Аудитын гэрчилгээ
- Хавсралт 2: Менежментийн захидал
- Хавсралт 3: Аудит хийгдсэн санхүүгийн тайлан
- Хавсралт 4: Төсвийн гүйцэтгэлийн тайлан
- Хавсралт 5: Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

АГУУЛГА

1.	Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл.....	3
2.	Байгууллагын хууль, эрх зүйн орчин.....	3
3.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа.....	4
4.	Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн.....	4
5.	Дотоод хяналт.....	5
6.	Төсвийн орлого, зардлын гүйцэтгэлийн талаар.....	5
7.	Шилэн дансны мэдээлэл.....	6
8.	Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар.....	6
9.	Гол, онцлог гүйлгээний талаар.....	6
10.	Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар.....	7
11.	Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар.....	8
12.	Анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	8
13.	Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд.....	8
14.	Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл.....	9
15.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	9
16.	Зөвлөмж	9
17.	Аудитын гэрчилгээний талаар санал дүгнэлт.....	9

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.2, Төсвийн тухай хуулийн 8.9.2, 18.2-т заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Цаг уур орчны шинжилгээний газрын 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд (САГ/2016/8/САГ-ТТЗ) аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Цаг уур, орчны шинжилгээний газрын 2015 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын баталсан холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Цаг уур орчны шинжилгээний газрын 2015 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2016 оны 3 дугаар сарын 7-с 2016 оны 3 дугаар сарын 25-ны хооронд хийхээр төлөвлөн Үндэсний аудитын газрын САГ-ын шинжээч Н.Энхмэнд хэрэгжүүлэв.

Цаг уур орчны шинжилгээний газрын 2015 оны санхүүгийн тайланг 2016 оны 3 дугаар сарын 04- ний өдөр Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин

Цаг уур орчны шинжилгээний газар нь Төсвийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Нийгмийн даатгалын тухай, Татварын тухай, Иргэний тухай, Ус цаг уур орчны хяналт шинжилгээний тухай хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хуульд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа

Ус цаг уур, орчны шинжилгээний газрын эрхэм зорилго нь ус, цаг агаарын урьдчилсан болон сэрэмжлүүлэх мэдээ, байгаль орчны мэдээллээр нийгмийн хэрэгцээг шуурхай хангах, байгалийн гамшгаас сэрэмжлүүлэхэд оршино.

Агентлаг нь дор дурдсан үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлтэй ажиллана:

- Монгол Улсын хэмжээнд ус цаг уур, байгаль орчны төлөв байдал, чанарын хяналт шинжилгээг зохион байгуулж хэрэглэгчийг мэдээллээр шуурхай хангах, ус, цаг агаарын аюулт үзэгдлийн улмаас үүсч болзошгүй гамшгийн эрсдэлээс эртнээс сэрэмжлүүлэх;
- Ус цаг уур, орчны чанарын хяналт шинжилгээний улсын сүлжээг нэгдсэн удирдлага, нэгдмэл арга зүйгээр хангах, өргөжүүлэх, чадавхийг бэхжүүлэх;
- Ус цаг уур, байгаль орчны чанарын хяналт шинжилгээний улсын сүлжээний үйл ажиллагааг тасралтгүй явуулж мэдээлэл цуглуулах, түүнийг хэрэглэгчид шуурхай хүргэх техникийн найдвартай ажиллагааг хангах, техник технологийн байнгын шинэчлэл хийх;
- Байгаль орчны улсын мэдээллийн сан, архив үүсгэх ажлыг удирдан зохион байгуулах, хэрэглэгчдийг мэдээллээр үйлчлэх.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн

Цаг уур, орчны шинжилгээний газарт хамрагддаг 27 төсвийн шууд захирагчидын аудитад 27 нь хамрагдсан ба нийт төсөвт зардлын 26 хувийг Үндэсний аудитын газар, 65 хувийг Аймаг, нийслэлийн аудитын газар, 9 хувийг Хараат бус аудитын компаниуд тус тус хамарч санхүүгийн тайланд аудит хийсэн байна.

Аудитад хамрагдсан 27 салбар, нэгжийн 17 байгууллага нь “Зөрчилгүй”, 4 байгууллага нь “Хязгаарлалттай”, 2 байгууллага буюу Нислэгийн цаг уурын газар болон Цаг уур орчны шинжилгээний газрын төв аппарат нь Цаг уур, орчны шинжилгээний газрын даргын төсвийн багцын аудитад түүврээр хамрагдсан байна.

Мөн Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2015 оны 240 дүгээр тушаалаар баталсан “Санхүүгийн тайлангийн аудитад итгэл үзүүлэхэд баримтлах журам”-ын шаардлагыг хангаж байгаа 3 байгууллагад Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар

зүйлийн 18.4-т заасны дагуу 2015 оны санхүүгийн тайланд итгэл үзүүлж, “ЗӨРЧИЛГҮЙ” санал дүгнэлт өгсөн байна.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Цаг уур, орчны шинжилгээний газрын 2015 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Гүйцэтгэлийн шатанд санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан 8 горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Материаллаг байдлын түвшингийн суурийг тус байгууллагын 2015 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагын 2 хувиар тооцож 426.6 сая төгрөгөөр тогтоосон болно. /ТАБ-СТА-В1/

Тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг “Acolous” програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

Дотоод хяналтын талаар

Дотоод аудит нь байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, үнэ цэнийг нэмэгдүүлэхэд чиглэсэн хараат бус, бодитой баталгаа өгөх ба зөвлөх үйл ажиллагаа юм. Дотоод аудитын ажлын гол зорилго нь эрсдэлийг тодорхойлж, үнэлэхэд удирдлагад туслахад оршиж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 129 дүгээр тогтоолоор Дотоод аудитын дүрмийг баталсан ба энэ дүрэм нь ТЕЗ-ийн дотоод аудитын үйл ажиллагааны зорилго, хамрах хүрээ, зарчим, зохион байгуулалт болон дотоод аудиторын эрх, үүргийг тодорхойлж, дотоод аудитын үйл ажиллагааг явуулах, хөндлөнгийн аудитын байгууллагатай хамтран ажиллах харилцааг зохицуулсан байна.

Цаг уур орчны шинжилгээний газар нь дотоод аудитын албагүй бөгөөд БОАЖНХЯ-ны хяналт, шинжилгээ дотоод аудитын газраас батлагдсан хуваарийн дагуу дотоод аудит хийж, өгсөн зөвлөмжийн дагуу ажилладаг байна.

Төсвийн орлого, зардлын гүйцэтгэлийн талаар

2015 оны батлагдсан төсвийг сар, улиралын хуваарийн дагуу салбарын яамны төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээнд мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэхэд хяналт тавин ажилласан болно.

Цаг уур орчны шинжилгээний газарт 2015 онд улсын төсвөөс урсгал зардалд 21,478.1 сая төгрөгийн санхүүжилт, төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлого 115.4 сая төгрөг, төсвийн урамшуулал, Засгийн газрын нөөц хөрөнгө, нэмэлт орлого, хандив тусламжаар нэмэлт дансаар 780.5 сая төгрөг төгрөг, нийгмийн даатгалын сангаас 40.5 төгрөгийн санхүүжилт тус тус олжээ.

Үүнээс урсгал зардалд 21,886.2 сая төгрөг батлагдсанаас 21,334.5 сая төгрөгийг зарцуулж, батлагдсан төсвөөс 264.8 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн талаар

Шилэн дансны мэдээллийг цаг уур орчны шинжилгээний газруудын харьяа газруудын нягтлан бодогч нар хариуцан оруулдаг. Shilendans.gov.mn веб сайтаар мэдээлэлээ тус бүр оруулж байна. Шилэн дансны хэрэгжилтийн талаар улирал бүр БОНХАЖЯ-наас нэгтгэсэн тайлан авч зөвлөмжийн хэрэгжилтэнд хяналт тавьдаг.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 14 эрсдэлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 8 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Гол, онцлог гүйлгээний талаар

Тус байгууллагын 2015 оны санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, орлого, зардал зэрэг дансдын ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар

Аудитын явцад мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлого, нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэж гаргах аргачлалын дагуу ажил гүйлгээг бүртгэлд тусгасан байдал, дансны болон ерөнхий журнал, ерөнхий дэвтэр зэрэг хураангуй бичилтийг арга зүйн хувьд нягтлан үзэж санхүүгийн тайлангийн илэрхийлэлд үнэлэлт өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад материаллаг бус дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

1. Цаг уур орчны шинжилгээний газрын санхүүгийн тайланд нийт 27 төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайланг нэгтгэсэн байна. Төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар 30.1 сая төгрөгийн 32 зөвлөмж өгөгдсөн байна. Нийт өгөгдсөн зөвлөмжийн 43.7 хувийг нягтлан бодох бүртгэл хөтлөлт, тайлагналын алдаатай илэрхийлсэн зөрчлүүд эзэлж байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7 д “Анхан шатны баримтгүй ажил гүйлгээг бүртгэл, тайланд тусгахыг хориглоно”, 19 дүгээр зүйлийн 19.1.5- д “эд хөрөнгө, өр төлбөрийн хүчин төгөлдөр бус баримтаар ажил гүйлгээг бүртгэл, тайланд тусгахыг хориглоно”, Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д “Төсвийн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу бүрэн аккруз суурьтай нягтлан бодох бүртгэл хөтлөнө” гэсэн заалттай тус тус нийцэхгүй байна. Мөн Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалаар батлагдсан "Төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэх заавар"-ыг тус тус мөрдөж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7, 19 дүгээр зүйлийн 19.1.5, Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 болон Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалыг мөрдөх, төсвийн шууд захирагчидад тавих дотоод хяналтыг сайжруулж ажиллах шаардлагатай байна.

2. Нийт өгөгдсөн зөвлөмжийн 21.8%- ыг бараа материал, үндсэн хөрөнгийн бүртгэлийг алдаатай буруу хөтөлсөн, тооллогод бүрэн хамруулаагүй зэрэг зөрчлүүд эзэлж байна.

Энэ нь УСНББОУС 17, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6- д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, Санхүүгийн тайлангийн Үнэн зөв байх батламж мэдэгдэлд “аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайланд тусгасан ажил гүйлгээ, үлдэгдэл нь тооцооллын алдаагүй, зөв хураангуйлж бүртгэсэн болон түүнийг зохицуулж буй хууль тогтоомжуудтай нийцэж байх” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6- г мөрдөж ажиллах, мөн хөрөнгийн тооллогыг чанартай цаг хугацаанд нь гүйцэтгэж, үндсэн хөрөнгө, бараа материалын бүртгэл тооцооллыг үнэн зөв хийж ажиллах зөвлөмж өгсөн болно.

3. Цаг уур, орчны шинжилгээний газрын 2015 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт 136.4 сая төгрөгийн авлагатай байна. Үүнд ажиллагсадтай холбогдсон авлага 2.2 сая, төлбөртэй үйлчилгээний авлага 9.5 сая, татаас, санхүүжилтийн авлага 101.2 сая, байгууллагаас авах авлага 20.3 сая, хувь хүмүүсээс авах авлага 2.9 сая төгрөг байна.

Нийт 245.3 сая төгрөгийн өглөгтэй байна. Хувь хүмүүст өгөх өглөг 16.9 сая, байгууллагад төлөх өглөг 210.6 сая, ажилчидтай холбогдсон өглөг 7.0 сая, бараа үйлчилгээний зардлын өглөг 10.7 сая төгрөг байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 6 дугаар зүйлийн 6.4.8 дах заалтуудыг мөрдөж ажиллах, тайлант онд үүссэн 245.3 сая төгрөгийн өр төлбөр, 136.4 сая төгрөгийн авлагыг барагдуулах, цаашид авлага, өр төлбөр үүсгэхгүй байхаар зөвлөмж өгсөн болно.

4. Цаг уур, орчны шинжилгээний газрын харилцах дансны нийт 2,280.3 сая төгрөгийн 736 ажил гүйлгээнээс, 2,216.0 сая төгрөгийн 222 ажил гүйлгээг түүвэрлэн шалгахад гадаад томилолттой холбоотой нийт 14.5 сая төгрөгийн анхан шатны баримтын бүрдэл дутуу байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-т “анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 7.7-т “Анхан шатны баримтгүй ажил гүйлгээг

бүртгэл, тайланд тусгахыг хориглоно.” мөн санхүүгийн тайлангийн Иж бүрэн байх батламж мэдэгдэлд “аж ахуй нэгж байгууллага тайлант хугацаанд гарсан бүх ажил гүйлгээ, үлдэгдэл буюу үйл явдал, нөхцөл байдлуудаас бүртгээгүй, нэмж тодруулаагүй, орхигдуулсан зүйлсгүй байх” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 7.7- г мөрдөж ажиллах зөвлөмж өгсөн болно.

5. Цаг уур, орчны шинжилгээний газрын Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт хүчингүй болсон эрхийн актыг мөрдөж ажиллахаар тусгасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.2- т “аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг хууль тогтоомжид нийцүүлэн шинэчлэн боловсруулан батлуулах.

Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар

Аудитаар залруулагдаагүй алдаа байхгүй болно.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал

Аудитаар анхаарал татахуйц чухал асуудал байхгүй болно.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд

Цаг уур орчны шинжилгээний газрын 2015 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

Цаг уур орчны шинжилгээний газрын 2015 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 396.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба дээрх зөрчлийг арилгах 5 зөвлөмж өгсөн болно.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

2014 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар УАГ-аас 3 зөвлөмж өгсөн байна. Дээрх зөвлөмж 100 хувь биелсэн байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

Цаг уур орчны шинжилгээний газар 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

Аудитлагдсан санхүүгийн тайлан /. . . хуудас/-ыг хавсаргав.